



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 17 сарын 17 өдөр

Дугаар А/110

Номгон

Баянхонгор сумын 2,3,7,9 багийн гэр хорооллын гэрэлтүүлэг, камержуулалт, интернет орчин бүрдүүлэх, гамшгийн үеийн дохиоллын сирена суулгах гэрээний гүйцэтгэлд хяналт хийж, хүлээн авах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.6 дахь заалт, Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 131/ШШ2024/00597 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймаг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2018-2020 онд батлагдсан “Баянхонгор сумын 2,3,7,9 багийн гэр хорооллын гэрэлтүүлэг, камержуулалт, интернет орчин бүрдүүлэх, гамшгийн үеийн дохиоллын сирена суулгах” 271.1 сая төгрөгийн төсөвтэй ажлын гүйцэтгэлийг хүлээн авах, дүгнэлт гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: П.Отгонбаяр (Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга),

Гишүүд: Г.Ганчулуун (Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн дарга)

Г.Энхбаяр (Баянхонгор сумын Засаг дарга)

Т.Норовринчин (Дэд бүтэц, барилга, орон сууцны бодлого хариуцсан мэргэжилтэн)

М.Батзаяа (Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн Мэдээлэл технологи хариуцсан мэргэжилтэн)

Г.Мөнгөнсүх (Цагдаагийн газрын холбоо мэдээллийн инженер Цагдаагийн ахмад) Г.Баярсайхан (Онцгой байдлын газрын гамшгаас хамгаалах, төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах Хяналтын улсын байцаагч, хошууч)

824010990

Б.Бадамцэцэг (“Баянхонгор-Эрчим хүч”) ЦТХХК-ний Ерөнхий инженер

Л.Одончимэг (Мэдээлэл холбоо сүлжээ ТӨХК-ний Баянхонгор аймаг дахь салбарын Ерөнхий инженер),

Н.Пүрэвжаргал (Баянхонгор сумын Захирагчийн ажлын албаны дарга),

Ч.Баттулга (“Баттод” ХХК-ний Захирал),

Нарийн бичгийн дарга: Б.Ичинхорлоо (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн Хөрөнгө оруулалтын мэргэжилтэн)

2.Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2018-2020 онд батлагдсан “Баянхонгор сумын 2,3,7,9 дүгээр багийн гэр хорооллын гэрэлтүүлэг, камержуулалт, интернет орчин бүрдүүлэх, гамшгийн дохиоллын серена суулгах” 271.1 сая төгрөгийн төсөвтэй ажлыг 2024 оны 07 дугаар сарын 22-ны дотор хүлээлцэж танилцуулахыг ажлын хэсэг /П.Отгонбаяр/-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Б.Батсуурь/-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН